



# СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

157 /157/

2021.10.15

ТУСГАЙ ДУГААР




ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН ТҮҮХТ 100 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН МЭНДИЙГ ДЭВШҮҮЛЬЕ!



БИДНИЙ СУРГУУЛЬ 100 НАС ХҮРЛЭЭ

## ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНТ СУРГУУЛЬ



Монгол Улсын мэргэжлийн боловсролын ууган сургууль болох Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн түүхт 100 жилийн ой энэ өдөр тохиож байна.

1921 онд үүсэн байгуулагдсан цагаасаа улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг батлан хамгаалах, Зэвсэгт хүчний үеийн шилдэг офицер, даргалах бүрэлдэхүүнийг сурган бэлтгэх үндсэн үүрэг зорилгоо нэр төртэй гүйцэтгэж, өнөөгийн шинэ зууны дээд боловсрол, сургалтын тогтолцоон дахь нэр хүнд, байр суурь улам бүр өсөн нэмэгдсээр байгаа юм.

Түүхт 100 жилийн ойтойгоо золгож буй УБХИС-ийн хүндэтгэлийн баярын хурал яг энэ цаг мөчид УБХИС-д зохион байгуулагдаж байгаа бөгөөд тус ёслолын арга хэмжээнд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг нар болон бусад хүндэт зочид төлөөлөгчид оролцож байна

(Үргэлжлэл нь II нүүрт)



## МЭНДЧИЛГЭЭ



Монгол Улсын шинэ цагийн боловсролын эхлэлийг тавилцсан ууган их сургуулиудын нэг Сүхбаатарын болон Байлдааны гавьяаны улаан тугийн

одонт, жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит Үндэсний батлан хамгаалахын их сургууль үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн баярын мэндийг тус сургуулийн үе үеийн удирдлага, эрдэмтэн багш, судлаачид, ажилтан албан хаагчид, нийт төгсөгчид Та бүхэндээ өргөн дэвшүүлж!

Монгол орныг шинэ нийгэмд хөтөлж, хөгжил дэвшлийн замд эргэлт буцалтгүй оруулсан Ардын хувьсгалтай нас чацуу тус сургууль нь 1921 онд Ардын цэргийн даргын сургууль нэртэйгээр 90 сурагчтай анх байгуулагдаж, гал голомтоо бадраасан тэр цагаас хойш нэгэн зууны түүхийг бүтээж, сургалт, хүмүүжлийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж, эх орноо гэсэн чин сэтгэлтэй, цэргийн эрдэм ухаанд төгс боловсорсон, бие бялдар, сэтгэлзүйн өв тэгш хүмүүжилтэй, ёс суртахууны өндөр төлөвшилтэй мянга мянган даргалах бүрэлдэхүүн, шилдэг сэхээтнүүд, чадварлаг мэргэжилтнүүдийг бэлтгэн гаргаж, эдүгээ боловсролын салбарт хэдийнээ хүлээн зөвшөөрөгдсөн

Монгол Улсын үндэсний хэмжээний томоохон их сургууль болтлоо өргөжин хөгжиж төлөвшсөн билээ.

Тус сургуулийн бие бүрэлдэхүүн төр улсынхаа тусгаар тогтнол, эх нутаг, газар шорооныхоо бүрэн бүтэн байдлын төлөө 1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны Чөлөөлөх дайнд оролцож эгнээнээсээ олон арван баатрууд, халуун эх орончдыг төрүүлсэн бахархам үйлсийг бүтээн эх орныхоо өмнө байгуулсан алдар гавьяа, үйл хэргээ төр засаг, ард түмэндээ үнэлүүлж, төрийн хүндэт одонгоор хоёронтоо шагнагдсан бахархам үйлсийн эзэд билээ.

Өнөөдөр тус сургууль нь Монгол Улсын аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах салбарын даргалах бүрэлдэхүүн, мэргэжилтнийг бэлтгээд зогсохгүй орчин цагийн нийгмийн эрэлт хэрэгцээг хангахуйц чадварлаг алба хаагчдыг бэлтгэн эх орныхоо хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмрээ оруулж байгаагийн зэрэгцээ тус сургуулийн

төгсөгчид эх орныхоо бүхий л салбарт эрдэм мэдлэг, авьяас билиг, өрсөлдөх чадвараараа шалгарч амжилттай хөдөлмөрлөж байгаа төдийгүй даян дэлхийд энх тайван, амар амгаланг тогтоох эрхэм хүндтэй үйлсэд манлайлан оролцож суу алдраа дуурьсгасаар байгаа нь эрдэмтэн багш, судлаачид, ажилтан албан хаагчид, сонсогч, төгсөгчид та бүхний хамтын хичээл зүтгэлийн үр дүн гэдгийг бахархан дурдахад таатай байна.

Эрдэм мэдлэг, оюун ухаан шинэ зууны хөгжлийн түлхүүр болж буй XXI зуунд Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн хамт олон Та бүхнийг боловсролын тэгш, чанартай үйлчилгээг үзүүлж, чадварлаг хүний нөөцийг бэлтгэх, туршилт судалгаанд суурилсан шинжлэх ухаанч хөгжлийн түүчээ нь болон төлөвших эрдмийн их үйлсэд тань улам их амжилтыг хүсэн ерөөе!

Төр улсын минь гал голомт мөнхөд бадарч, түмэн олны минь үйл хэрэг ашид дэлгэрэх болтугай!

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Г.САЙХАНБАЯР

Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит, Сүхбаатарын болон Байлдааны гавьяаны улаан тугийн одонт Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн эрдэмтэн, багш, судлаач, эрхэм генерал, офицер, ахлагч, ажилтан албан хаагч, сонсогч, сурагч, түрүүч, байлдагч, бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмад дайчид, нийт төгсөгчид Та бүхэнд тус сургуулийн нэгэн зууны түүхт ойн баярын мэндийг өргөн дэвшүүлж!

Түүх сөхвөөс Ардын түр Засгийн газар, Намын Төв хорооны 1921 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн хамтарсан хурлаас цэргийн байгуулалтын асуудлыг хэлэлцэж гаргасан тогтоолд "... цэргийн сургууль нээн монгол цэргүүдээс ухаан сэргэлэнг цэргийн сургуульд боловсруулж, сургагч дарга нарыг сурган гаргаж авбаас зохино" хэмээн заасан нь манай улсад анхны цэргийн сургуулийг байгуулах албан ёсны шийдвэр байсан ба 1921 оны 10 дугаар сарын 15-ны өдөр анхны хичээлээ эхлүүлсэн түүхтэй.

Ийнхүү жанжин Д.Сүхбаатарын шууд удирдлага, санаачилгаар байгуулагдсан Ардын цэргийн даргын сургууль нь үндэсний цэргийн мэргэжилтнийг бэлтгэх үндэс суурийг тавьсан бол Бүх цэргийн ерөнхий сургууль нь Ардын журамт цэргийг байнгын

цэрэг болгон хөгжихөд ихээхэн хувь нэмэр оруулжээ. Улмаар Цэргийн ерөнхий сургууль болж Монгол Ардын Хувьсгалт Цэргийн даргалах бүрэлдэхүүнийг сургаж, давтан бэлтгэх гол уурхай нь болсны зэрэгцээ суралцагсдыг зөвхөн цэргийн эрдэмд сургаад зогсохгүй, эх орныхоо хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалтын бүхий л салбарт ажиллахаар бэлтгэсэнээр онцлогтой байлаа.

Энэ хугацаанд тус сургуулийн удирдлага, төгсөгчид нь 1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны Чөлөөлөх дайнд Монгол Ардын Хувьсгалт Цэргийн даргалах бүрэлдэхүүний цөмийг бүрдүүлж, гарамгай гавьяа байгуулсныг түүх мартах учиргүй.

Орчин цагийн Зэвсэгт хүчний хөгжил, нийгмийн өөрчлөлттэй уялдуулан Цэргийн ерөнхий дээд сургууль, Цэргийн нэгдсэн дээд сургууль, Цэргийн их сургууль, Батлан хамгаалахын их сургууль болж өргөжин хөгжиж, Зэвсэгт хүчний хэрэгцээ, шаардлагад нийцсэн олон зуун офицер, ахлагчийг бэлтгэж, дэвшүүлсэн зорилго, зорилтуудаа амжилттай биелүүлсээр ирсэн бөгөөд Монгол Улсын боловсролын тогтолцоонд нэн чухал байр суурийг эзлэн үндэсний хэмжээний сургалт, судалгааны төв болж өргөжсөнийг манай улсын төр, засаг, цэргийн дээд командлал, иргэд өндрөөр үнэлдэг юм.

Өдгөө энэхүү сургуулийг төгсөгчид нь Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний төдийгүй төрийн цэргийн байгууллагуудын хүний нөөцийн гол цөмийг бүрдүүлж, улс орныхоо хөгжил дэвшил, бүтээн байгуулалт, энхийг дэмжих ажиллагаанд идэвх зүтгэлтэй оролцож, цэргийн шинэчлэлийг эрчимжүүлэх, эх орон, төр, ард түмнийхээ өмнө хүлээсэн үүргээ нэр төртэйгөөр биелүүлэх, ирээдүй хойч үеийг цэрэг-эх оронч үзэл, хүмүүжлээр төлөвшүүлэх үйл хэрэгт үнэлж баршгүй хувь нэмэр, гавьяа зүтгэл гаргаж буйг баярын энэ өдөр онцлон тэмдэглэе.

Цаашид нэгэн зууны гараан дээр төрөлх сургуулийнхаа түүх, дайчин уламжлалаа баяжуулан, эрдэм шинжилгээ, сургалтын чанараар өөрийн эх орондоо төдийгүй олон улсад манлайлан өрсөлдөх, хөрвөх чадвартай чадварлаг мэргэжилтнүүдийг бэлтгэх, орчин үеийн дэвшилтэт технологи бүхий сургалтын хэрэгслээр материаллаг баазаа бэхжүүлэх, бие бүрэлдэхүүний ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах чиглэлээр улам бүр идэвх санаачилгатай ажиллана гэдэгт итгэл төгс байна.

Энэхүү түүхт 100 жилийн ойг тохиолдуулан бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмад дайчид, тус сургуульд ажиллаж байсан болон өдгөө ажиллаж буй генерал, офицер, ахлагч, ажилчин албан хаагч,



сонсогч, сурагч, түрүүч байлдагч нарт дахин баярын мэндийг дэвшүүлж, ажлын арвин их амжилт, амьдралын сайн сайхан бүхнийг бэлгэдэн ерөөе.

МОНГОЛ ЦЭРГИЙН ЯРУУ АЛДАР, СУР ХҮЧ, СҮЛД ХИЙМОРЬ МАНДАН БАДРАХ БОЛТУГАЙ! ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН ДАРГА, ДЭСЛЭГЧ ГЕНЕРАЛ Д.ГАНЗОРИГ



# БИДНИЙ СУРГУУЛЬ 100 НАС ХҮРЛЭЭ

## 100 ЖИЛИЙН ТҮҮХЭНД...

Монгол Улсын баатар 11, Монгол Улсын ардын багш 1, Гавьяат багш 8, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн 4, Гавьяат тамирчин 2, Шинжлэх ухааны доктор 12, Боловсролын доктор 118

## ҮБХИС-ИЙН ОНЦЛОХ 10 ҮЙЛ ЯВДАЛ

**Нэг:** Анхны ууган их сургууль. ҮБХИС бол Монгол Улсын анхны мэргэжлийн боловсролын ууган их сургууль юм. Ардын хувьсгалтай нас чацуу тус сургууль нь тэртээ 1921 оны 8 дугаар сард байгуулагдан 10 дугаар сарын 15-ны өдөр анхны 28 сурагчтайгаар үйл ажиллагаагаа эхлүүлжээ. Нэгэн зуун жилийн хугацаанд тус сургууль нь 70 мянга гаруй боловсон хүчнийг бэлтгэн гаргажээ.

**Хоёр:** Алдар суутны өлгий. ҮБХИС-аас хамгийн олон Монгол Улсын баатар цолтон төржээ. Монгол Улсын 11 баатар цолтон энэ сургуулиас мэндэлжээ. Тэд Халхын голын дайн, Чөлөөлөх дайн, Баруун хилийн тулгаралт зэрэгт оролцжээ.

**Гурав:** Төрийн тусгай байгууллагуудын боловсон хүчний цөмийг бүрдүүлэгч. Эдүгээ батлан хамгаалах салбарын боловсон хүчний 90 хувийг, хилийн цэрэг, онцгой байдал, авто замын цагдаагийн гээд олон салбарын боловсон хүчнийг тус сургууль 100 жилийн хугацаандаа бэлтгэн гаргасан байна.

**Дөрөв:** Өнөөдрийн байдлаар ҮБХИС-ийн багш судлаачдын 40 хувь нь доктор, Ардын багш 1, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн 3, Гавьяат багш 8 байна.



**Тав:** Монгол Улсын Ерөнхийлөгчийг төгсгөсөн сургууль. Монгол Улсын зургаа дахь Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Ухнаагийн Хүрэлсүх тус сургуулийн Улс төрийн ангийг 1985-1989 онд суралцан төгсөж ажил амьдралын гараагаа эхлүүлж байжээ.

**Зургаа:** Хамгийн олон цэргийн дээд цолтонтой. Тус сургуулийн түүхэн дэх цэргийн хамгийн өндөр дээд цолтон бол тус сургуулийн 1922 оны төгсөгч, маршал, өрлөг жанжин Г.Дэмид юм. Мөн армийн генерал, хурандаа генерал, дэслэгч генерал, хошууч генерал, бригадын генерал цолтон гээд 90 гаруй хүн тус сургуулийг төгсжээ.

**Долоо:** Тус сургуулийн бүтэц дэх "Тэмүүжин Өрлөг" бүрэн дунд сургууль нь Монгол Улсын боловсролын тогтолцоон дахь ууган дунд сургуулиудын нэг юм. Учир нь Ардын Хатанбаатар С.Магсаржавын санаачилга, МАХН-ын Төв Хорооны шийдвэрээр 1925 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Цэргийн Ерөнхий сургуулийн дэргэд 10-15 насны хөвгүүдийг сургаж зургаан жилийн сургалтын хөтөлбөртэй Д.Сүхбаатарын нэрэмжит сургуулийг, мөн БНМАУ-ын Цэргийн яамны сайд бөгөөд Бүх цэргийн жанжны 1937 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 310 тоот тушаалаар Цэргийн ерөнхий сургуульд шилжин орох сурагчдыг бэлтгэх зорилго бүхий Сүхбаатарын сургуулийг тус тус байгуулсан байдаг. Энэ сургуулиуд нь МАХЦ-т үндэсний цэргийн дарга нарыг сургаж бэлтгэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан төдийгүй "Тэмүүжин Өрлөг" бүрэн дунд сургуулийн үүсэл хойшид уламжлагдах түүх нь болж өгсөн байна.

**Найм:** ҮБХИС нь олон улсын энхийг сахиулах ажиллагаанд оролцогчдын 90 гаруй хувийг бэлтгэн гаргасан юм. Тус сургуулийн бүтэц дэх Батлан хамгаалахын мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийг төгссөн ахлагч нарын 98 хувь нь олон улсын энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэдгээрээ онцлогтой.

**Ес:** Хамгийн хамгийн. Тус сургуулийн хамгийн анхны ардын багш бол Г.Мягмаржав, анхны гавьяат багш Д.Санжсүрэн, анхны шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн Д.Мягмар, анхны шинжлэх ухааны доктор хошууч генерал Ц.Геннадий нар юм.

**Арав:** Эрдэм шинжилгээ судалгааны тэргүүлэх их сургууль. Тус сургууль нь эрдэм шинжилгээ судалгааны чиглэлээр Монгол Улсдаа тэргүүлэх эгнээнд явдаг. Ялангуяа цэргийн түүх, аюулгүй байдал, цэргийн техник технологийн чиглэлээр тэргүүлэх хэмжээний судалгаа явуулдаг гэдгээрээ хүлээн зөвшөөрөгдсөн билээ.

**БХЭШХ-ийн Цэргийн түүх судлалын төвийн дарга, доктор (Ph.D), дэд профессор, хошууч Т.СҮХБААТАР**

## Түүхэн товчоон

1921

### Ардын цэргийн даргын сургууль

Ардын түр засгийн газар ба Намын Төв хорооны 1921 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн хамтарсан хурлаас цэргийн байгуулалтын асуудлыг хэлэлцэж гаргасан тогтоолд "... цэргийн сургууль нээн монгол цэргүүдээс ухаан сэргэлэнг цэргийн сургуульд боловсруулж, сургагч дарга нарыг гарган сургаж авбаас зохино" хэмээн заасан нь анхны цэргийн сургуулийг байгуулах албан ёсны шийдвэр байж, улмаар 1921 оны 10 дугаар сарын 15-нд анхны хичээл сургалтаа эхлүүлжээ.

1923

### Бүх цэргийн ерөнхий сургууль

Бүх цэргийн зөвлөлийн 1923 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 10 дугаар хурлаар "Даргын сургуулийг шинэчлэн байгуулах тухай" түр дүрмийг хэлэлцэж, "Ардын цэргийн даргын сургууль"-ийг 1923-1924 оны хичээлийн жилээс эхлэн 3 жилийн сургалттай "Бүх цэргийн Ерөнхий сургууль" болгон өргөжүүлжээ.

1932

### Цэргийн ерөнхий сургууль

МАХН-ын Төв Хорооны 1932 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн тогтоолоор Бүх цэргийн Ерөнхий сургуулийг МАХН-ын Төв Хорооны нэрийн Цэргийн Ерөнхий сургууль болгон өргөтгөн зохион байгуулж, сургуулийн бүтэцэд морин цэрэг,

улс төр, пулемёт, их буу, хуягт тэрэг, танк, бэлтгэл ба бага ястны гэсэн 8 ангитай байхаар тогтоосон. 1939 оны Халхын голын дайн, 1945 оны Чөлөөлөх дайны жилүүдэд цэргийн боловсон хүчнийг сургаж бэлтгэх үүрэг, зорилтоо амжилттай гүйцэтгэсэн төдийгүй БНМАУ-ын Бага хурлын Тэргүүлэгчид, Ардын Сайд нарын Зөвлөлийн 1932 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор "Цэргийн гавьяаны нэгдүгээр зэргийн одон" тэмдгээр шагнагдаж, БНМАУ-ын Бага хурлын Тэргүүлэгчдийн 1947 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 35 дугаар тогтоолоор "Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит сургууль" болгон алдаршуулсан байна.

1964

### Цэргийн ерөнхий дээд сургууль

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоолыг үндэслэн БХЯ-ны сайдын 1967 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн н/28 дугаар тушаалын дагуу "Цэргийн Ерөнхий дээд сургууль" болгон өргөтгөн зохион байгуулснаар дээд боловсролтой улс төрийн ажилтан бэлтгэх эхэлсэн байна. 4 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлж, бүтэц зохион байгуулалт нь сургуулийн захирал, намын хороо, сурах анги, жагсаал анги, боловсон хүчин, нууц, аж ахуй, санхүү тооцооны анги, хүн эмнэлэг, авто тракторын алба, зэвсгийн албаас бүрдэж байв. Энэ цаг үед Төрийн дээд шагнал Сүхбаатарын одонгоор шагнагдсан юм.

1981

### Цэргийн нэгдсэн дээд сургууль

Цэргийн боловсрол сургалт, эрдэм шинжилгээний гол төв болж, 1976-1991 онд 20 удаагийн төгсөлтөөр дээд боловсролтой 2491 офицерыг сурган бэлтгэсэн нь түүхэндээ хамгийн олон төгсөгчтэй онцлог үе болсон.

1990

### Цэргийн их сургууль

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1991 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн 223 дугаар тогтоолоор ЦНДС-ийг "Цэргийн их сургууль" болгон өөрчлөн байгуулсан. Сургалтын төлөвлөгөөг 1992, 1994, 1997, 1999 онд шинэчлэн боловсруулж, цэрэг, иргэний худ мэрэгжилтэн бэлтгэх болсон. Батлан хамгаалахын удирдлагын академид цэргийн дээд боловсролтой, цэргийн шинжлэх ухааны магистрын зэрэгтэй офицер, Ахлагчийн сургуульд цэргийн тусгай мэргэжлийн ахлагч нарыг сургаж эхэлсний зэрэгцээ иргэний хамгаалалтын болон олон улсын энхийг дэмжих ажиллагааны шүхэрчин аврагч, элитийн батальонд алба хаах мэргэжлийн цэрэг, бага мэргэжилтэн, иргэний хамгаалалтын болон химийн цэргийн дээд боловсролтой офицер бэлтгэж эхэлсэн.

1999

### Монгол Улсын Батлан хамгаалахын их сургууль

Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 85 дугаар тогтоолыг үндэслэн Батлан хамгаалахын сайд болон Төрийн нарийн бичгийн дарга нарын 1999 оны 60 дугаар тушаалаар Батлан хамгаалахын их сургууль (БХИС) болгон өргөтгөн зохион байгуулсан нь тус сургуулийн түүхэн хөгжлийн шинэ үе юм. "Инженерийн боловсролд суурилсан цэргийн мэргэжилтэн бэлтгэх тогтолцоотой мэдлэгт суурилсан сургалтын арга зүйг нэвтрүүлэн, эрдэм шинжилгээ сургалтын ажлын нэгдлийг ханган багш, оюутан хамтарч мэдлэг бүтээх сургалтын аргад шилжин, хичээл сургалтыг куррач болон блокин арга зүйгээр төлөвлөн зохион байгуулж төгсөгчдөд тасралтгүй, хөгжих мэдлэгийн тогтолцоог нэвтрүүлж, эрдэм шинжилгээ, сургалтын олон талт бодлого, үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлсэн байна.

2016

### Үндэсний батлан хамгаалахын их сургууль

Монгол Улсын Засгийн газрын 156 дугаар тогтоолын дагуу их сургуулийнхаа түүхт 95 жилийн ойн үеэр Үндэсний батлан хамгаалахын их сургууль нэртэйгээр өргөтгөсөн зохион байгуулалтад орж, өнөөг хүртэл боловсрол, сургалтын үйл ажиллагаагаа амжилттай явуулж байна.

#### (Түрүүч нь II нүүрт)

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх ҮБХИС-ийн үе үеийн төгсөгчид, эрдэмтэн багш, оюутан залууст хандан "Монгол Улсын тусгаар тогтнол газар нутгийн бүрэн бүтэн байдал, халдашгүй дархан байдлыг хамгаалан бэхжүүлэхэд түүхэн үүрэг гүйцэтгэсэн Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн түүхт 100 жилийн ойн арга хэмжээнд оролцож буй Та бүхэндээ Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн болоод энэ сургуулийн бүтээгдэхүүний хувьд өөрийн зүгээс чин сэтгэлийн талархал илэрхийлж, халуун дотно мэндийг дэвшүүлье. Тус сургууль нь XX зууны Монголын түүхийн хамгийн том үйл явдал болох 1932 оны зэвсэгт бослого, 1939 оны Халхын голын дайн, 1945 оны Чөлөөлөх дайн, 1940-1950-аад оны баруун хилийн тулгаралт зэрэг эх орноо батлан хамгаалах үйл хэрэгт ямагт манлайлан хамгийн их голлох үүрэгтэй оролцож түргэвчилсэн болон богино хугацааны сургалтаар фронт руу олон зуун цэргийн даргалах бүрэлдэхүүн, цэрэг дайчид, шаардлагатай боловсон хүчнийг илгээж эх орноо батлан хамгаалах үүргээ нэр төртэй биелүүлэн эгнээнээсээ олон арван Монгол Улсын баатруудыг төрүүлснийг түүх гэрчилнэ. Өөрийн эгнээнээсээ Монгол Улсын олон арван баатрыг төрүүлэн гаргасан сургууль өнөөдөр хараахан үгүй. Ийм л бахархам түүхтэй бидний сургууль оршин тогтнох хугацаандаа цэргийн мэргэжлийн болон бусад мэргэжлийн 20 мянган гаруй боловсон хүчнийг бэлтгэн улс орны бүхий л салбарт нийлүүлсээр иржээ. Тус сургуулийн төгсөгчдөөс Монгол Улсын Ерөнхийлөгч, ерөнхий сайд, сайд,

хөдөлмөрийн баатар, гавьяатууд гээд олон мянган нийгмийн шилдэг элитүүдийг төрүүлэн гаргасан түүхэн гавьяаг байгуулжээ. Тийм ч учраас тус сургуулийг жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит болгон Сүхбаатарын болон Байлдааны гавьяаны улаан тугийн одонгоор шагнасан юм.

Аливаа сургуулийн сургалтын чанарыг төгсөгчдийн тоогоор хэмждэггүй билээ. Тус сургууль нь өнөөдөр үндэсний хэмжээний их сургууль болж төлөвшсөн бөгөөд эрдэм шинжилгээ судалгааны эрдмийн их сургууль болж хүлээн зөвшөөрөгдсөн ба цаашид ч улс орныхоо тусгаар тогтнол бүрэн эрхт байдал, бүтээн байгуулалтад олон мянган чадвартай боловсон хүчнийг зуу зуун жилээр бэлтгэн гаргасаар байх болно гэдэгт би гүнээ итгэж явдаг.

Монгол орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг батлан хамгаалахын төлөө халуун амь, бүлээн цусаа үл хайрлан баатарлаг гавьяа байгуулж, амь насаа зориулсан цэргийн сургуулийн захирал, сонсогч, төгсөгчид тэдгээрийн гэр бүлд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын нэрийн өмнөөс баяр хүргэж мэхийн ёсолж байна.

Эх орноо батлан хамгаалж, бүтээн байгуулах ариун үйлсэд гар бие, сэтгэл оюунаа харамгүй зориулж энэ сургуулийн дараагийн зуун жилийн түүхийг өртөөлөн авч яваа өнөө цагийн бие бүрэлдэхүүн та бүхэндээ ахин баярлалаа" хэмээв.

Мөн энэ өдөр түүхт ойн хүрээнд төрийн дээд одон медалиар шагнагдсан алба хаагчдын шагналыг гардуулсан юм.

## 100 ЖИЛИЙН БОСГОН ДЭЭР ГУРВАН ЭРДЭМТНЭЭР ХҮРЭЭГЭЭ ТЭЛЛЭЭ



ҮБХИС-ийн Эрдмийн зөвлөлийн хүндэтгэлийн хуралдаан энэ сарын 13-нд "Сүбээдэй" хурлын танхимд боллоо. Тус хурлаар ҮБХИС-ийн "Хүндэт доктор" цол хүртсэн доктор (Sc.D), профессор Б.Эрдэнэбат, доктор (Ph.D), профессор С.Баасанхүү, ҮБХИС-ийн "Хүндэт профессор" цол хүртсэн "Сэлэнгэпресс" ХХК-ий ерөнхий захирал М.Болд нарт хүндэт доктор, хүндэт профессорын өмсгөл өмсүүлэх, хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагаа болов.

Ийнхүү үүсэн байгуулагдсан цагаасаа улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг батлан хамгаалах, Зэвсэгт хүчний үе үеийн шилдэг офицер, даргалах бүрэлдэхүүнийг сурган бэлтгэх үндсэн үүрэг зорилтоо нэр төртэй гүйцэтгэж, өнөөгийн шинэ зууны дээд боловсрол, сургалтын тогтолцоон дахь нэр хүнд, байр сууриа нэмэгдүүлсээр ирсэн ҮБХИС түүхт ойн босгон дээрээ хоёр "Хүндэт доктор", нэг "Хүндэт профессор"-оор хүрээгээ тэллээ.